



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/17

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дүгээр зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Засгийн газрын 2022 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.5.7, 3.6.16 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хууль бус мод бэлтгэлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлын хяналт шалгалтын шатахууны зардалд 699,000 (зургаан зуун ерэн есөн мянга) төгрөг, бичиг хэргийн зардалд 188,000 (нэг зуун наян найман мянга) төгрөг, байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах талаарх нутгийн иргэдийн мэдлэг, хандлагыг дээшлүүлэх сургалт зохион байгуулах нөлөөллийн ажлын төслийн зардалд 3,000,000 (гурван сая) төгрөг, нийт 3,887,000 (гурван сая найман зуун наян долоон мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 3,887,000 (гурван сая найман зуун наян долоон мянга) төгрөгийг Байгаль хамгаалах сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын Төсвийн ерөнхий нягтлан бодогч (О.Отгонтуяа)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН